



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох баримт бичгийг үндэслэн санхүүжилтийг олгосон ч 4 төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгээгүй байна.

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	Товчилсон үгийн тайлал	4
	Хүснэгтийн жагсаалт	5
Аудитын менежер М.Бат-Амгалан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	6
Ахлах аудитор Б.Авирмэд	Бүлэг А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох баримт бичгийг үндэслэн санхүүжилтийг олгосон байна.	8
Аудитор Р.Аюуш	<i>А.1. Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулсан байна.</i>	8
2024 оны 4 дүгээр сар	<i>А.2. Өмнөх онуудад хэрэгжиж дуусаагүй 2 төсөл, арга хэмжээний үлдээдэл санхүүжилтийг 2023 оны төсвийн тухай хуульд тусгаагүй, эрх шилжсэн 3 төсөл, арга хэмжээнд нэмэлт гэрээ байгуулсан байна.</i>	10
	<i>А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.</i>	13
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 70453721, 70453799 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг Б. Эрх шилжээгүй 8, эрх шилжсэн 4 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь гүйцэтгээгүй байна.	18
	<i>Б.1. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу бүрэн хэрэгжүүлээгүй байна.</i>	18
	<i>Б.2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.</i>	25
	<i>Б.3. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг Төрийн өмчийн хорооны шийдвэр ирээгүйгээс данс бүртгэлд тусгаагүй байна.</i>	28
Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангом сум 3 дугаар баг, аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Бүлэг В. Хэрэгжсэн 3 төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд бүрэн хүрээгүй байна.	29
	<i>В.1. Хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж эхлээгүй байна.</i>	29
	<i>В.2. Хэрэгжүүлсэн 3 төсөл, арга хэмжээнд чанарын доголдол үүссэн байна.</i>	29
	Дүгнэлт	33
	Холбогдох байгууллагын санал	34
	Аудитын газраас өгөх тайлбар	37
	Зөвлөмж	38

Товчилсон үгийн тайлал:

УВА	Увс аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын их хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ЗТХС	Зам тээврийн хөгжлийн сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ТАХ	Төсөл, арга хэмжээ
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд
ЭШХО	Эрх шилжсэн хөрөнгө оруулалт

Хүснэгтийн жагсаалт		
№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1.	Зураг төсөв, магадлалын дүгнэлттэй төсөл арга хэмжээний мэдээлэл	8
Хүснэгт 2.	Техникийн тодорхойлолт, ажлын даалгавраар хийгдсэн төсөл арга хэмжээ	9
Хүснэгт 3.	Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний мэдээлэл	9
Хүснэгт 4.	Нэмэлтээр байгуулсан гэрээний мэдээлэл	11
Хүснэгт 5.	Тендерийн хэмнэлтийг хасаж тооцохгүйгээр гэрээ байгуулсан мэдээлэл	11
Хүснэгт 6.	Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний мэдээлэл	12
Хүснэгт 7.	2023 оны төсвийн тухай хуульд эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнгийн мэдээлэл	13
Хүснэгт 8.	Үнийн өсөлтийн нэмэлт санхүүжилт олгосон төсөл, арга хэмжээ, санхүүжилтийн дүн	14
Хүснэгт 9.	Тайлант онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний мэдээлэл	15
Хүснэгт 10.	Гүйцэтгэл дутуу он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний мэдээлэл	16
Хүснэгт 11.	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл, арга хэмжээний мэдээлэл	17
Хүснэгт 12.	Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан 2021, 2022 онд хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний мэдээлэл	18
Хүснэгт 13.	2023 онд хэрэгжүүлж дуусгахаар төсвийн тухай хуульд заасан 25 төсөл, арга хэмжээний мэдээлэл	19
Хүснэгт 14.	Эрх шилжин хэрэгжсэн 7 төсөл, арга хэмжээний мэдээлэл	23
Хүснэгт 15.	Он дамжин хэрэгжихээр төлөвлөсөн 8 төсөл, арга хэмжээний мэдээлэл	24
Хүснэгт 16.	Байнгын ашиглалтад хүлээн авсан 8 төсөл, арга хэмжээний мэдээлэл	27
Хүснэгт 17.	Бүртгэлд тусгаагүй төсөл, арга хэмжээний мэдээлэл	28

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/152 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийлээ.

Аудитын зорилт

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх;
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

Хамарсан хүрээ

Аудитыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэхээр төсвийн тухай хуулиар баталсан 46 төсөл, арга хэмжээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийлээ.

Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд санхүүжүүлэхээр баталсан 46 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн Засаг дарга болон түүний харьяа байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч зарим аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамрууллаа.

Арга зүй

Аудитад гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх

төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглав.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг нэгдсэн удирдамжаар хийх бөгөөд Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулан, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Авирмэд, аудитор Р.Аюуш нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын хөтөлбөрт тусгагдсан цаглаварт хугацаанд Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн төлөвлөгөөт аудитууд зэрэг хийгдсэнээс шалтгаалан Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрийг газар дээр нь очиж үзэж амжаагүй болно. Аудитын хүрээнд Улаангом сум болон хөдөөгийн 1 суманд очиж ажилласан бөгөөд бусад суманд хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг онлайнаар зургийг авч баримтжууллаа.

Ерөнхий зүйл

Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 21 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 1129, тухайн оноос эхлэн хэрэгжих 10, нийт 7,376.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1139 төсөл, арга хэмжээг 2,686.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Нийт санхүүжилтийн 75.4 хувийг 980 барилга, байгууламжид 18.3 хувийг 71 тоног төхөөрөмжид, 4.1 хувийг 71 их засварт, 2.2 хувийг 17 ТЭЗҮ боловсруулах төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулахаар тусгажээ. Мөн нийт 1139 төсөл, арга хэмжээний 77.5 хувь буюу 883 төсөл, арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдэд 2023 онд 2,686.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 97 хувь буюу 2,605.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлжээ.

Увс аймагт 2023 оны төсвийн тухай хуулиар 144.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 46 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 2023 онд олгох санхүүжилт нь 50.9 тэрбум төгрөг байна.

БҮЛЭГ:А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох баримт бичгийг үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

А.1. Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж буй 19 төсөл арга хэмжээнээс 2021-2022 онд хэрэгжиж дууссан 8, тайлант онд хэрэгжиж дууссан болон он дамжин хэрэгжиж байгаа 11 төсөл, арга хэмжээ байна. Тайлант оны 11 төсөл, арга хэмжээнээс зураг төсөв, магадлалын дүгнэлттэй, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон 10 төсөл, арга хэмжээ, ажлын даалгавар техникийн тодорхойлолтой 1 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 1. Зураг төсөв, магадлалын дүгнэлттэй төсөл арга хэмжээний мэдээлэл

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (сая.төгрөг)	Магадлалын дүгнэлт (огноо, дугаар)
1	X.1.1.45	Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/	5,129.0	2019.05.24 №651/2019
2	X.2.1.3	Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	6,804.8	2019.07.23 №1115/2019
3	XI.1.20	Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/	10,813.7	2019.11.13 №1945/2019
4	XII.1.1.15	Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/	1,939.8	2019.04.22 №38/2019
5	XII.1.1.79	3 дугаар 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар- "ТНХ" ХХК-ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл /Увс, Улаангом сум/	2,000.0	2022.02.17 №16/2022
6	XII.2.1.14	Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/	576.5	2022.07.07 №238/2022
7	XII.2.1.17	Баруун гол дээр баригдах замын байгууламж /Увс, Өлгий сум/	288.9	2022.10.18 №384/2022
8	XIII.1.21	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга багц1 Увс /Цагаан ултай гутлын кластер төвийн барилга /Улаангом/	2,978.4	2021.11.03 №1735/2021
9	XIII.1.28	Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/	2,311.0	2022.04.09 №537/2022
10	XII.1.4.4	Баруун 4 замын уулзварын өргөтгөл, 3 дугаар 10 жилийн тойрог хүртэлх авто замын шинэчлэлийн зураг төсөв /Увс, Улаангом сум/	74.2	2022.09.26 №1357/2022

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Хүснэгт 2. Техникийн тодорхойлолт, ажлын даалгавраар хийгдсэн төсөл арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

№	Хуулийн код	Хуулийн төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (сая.төгрөг)	Техникийн тодорхойлолт (Ажлын даалгаврын огноо)
1	XIII.3.16	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 1 буюу "Үхрийн үүлдэр угсааг сайжруулах"	150.0	2023.01.04
			Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц2 буюу "Хүлэмж болон түүнд шаардлагатай тоног төхөөрөмж"	300.0	2023.01.04
			Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 3 буюу "Цахим сургалтын тоног төхөөрөмж" (19 сумын ЕБС)	300.0	2023.01.11
			Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 4 буюу "Тэс суманд шаардлагатай тоног төхөөрөмж"	250.0	2023.03.29

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэж заасан байхад хуульд заасан шаардлага хангаагүй 2 төсөл арга хэмжээг 2022 онд эхлүүлж он дамжин хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний мэдээлэл

Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар баталсан огноо
XV.2.1.9	ЗТХС	Баруун голын бетон гүүр, 10 у/м /Увс, Өлгий сум/	Барилга байгууламж	2021.12.24
XV.2.1.15	ЗТХС	Хангилцагийн голын модон гүүр /Увс, Цагаанхайрхан сум/	Барилга байгууламж	2021.12.25

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Энэ нь Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт "Засгийн газар барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 32.1.11 дэх заалтад "Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Үүнээс шалтгаалан тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсөвт өртөг нэмэгдэх, зориулалт өөрчлөгдөх зэрэг сөрөг үр дагаврууд гарсан байна.

- Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд 300.0 сая төгрөгөөр 2022-2023 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан Хангилцагийн голын модон гүүр /Увс, Цагаанхайрхан сум/ зураг төсвийг боловсруулж магадлалаар ороход төсөвт өртөг нь 576.5 сая төгрөг болж 276.5 сая төгрөгөөр нэмэгдсэнийг 2023 оны төсвийн тухай хуульд нэмж тусгасан.
- Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд 300.0 сая төгрөгөөр 2022-2023 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан Баруун голын бетон гүүр, 10 у/м /Увс, Өлгий сум/ ТЭЗҮ-г боловсруулахад гүүр тавих боломжгүй тул 2023 оны төсвийн тухай хуульд баруун гол дээр баригдах замын байгууламж болгон өөрчилсөн. Түүнчлэн төсөвт өртөг нь 288.9 сая төгрөг болж 11.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

А.2. Өмнөх онуудад хэрэгжиж дуусаагүй 2 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг 2023 оны төсвийн тухай хуульд тусгаагүй, эрх шилжсэн 3 төсөл, арга хэмжээнд нэмэлт гэрээ байгуулсан байна.

Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуульд Увс аймагт хэрэгжихээр батлагдсан 46 төсөл, арга хэмжээнээс 2021, 2022 онд хэрэгжиж дууссан 13 төсөл, арга хэмжээ, он дамжин 2023 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн 25 төсөл, арга хэмжээ, он дамжин 2024 онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн 8 төсөл, арга хэмжээ байна. /Төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн Б.1 хэсэгт тодорхой тусгасан болно./

2019 оноос дамжин хэрэгжиж байсан 1 төсөл, арга хэмжээ 2023 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй орхигдсон байна.

- 4,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2019-2022 онд хэрэгжүүлэх Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/, 2019 онд БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “ЗУНБОО” ХХК шалгарч гэрээ байгуулан 2019, 2020 онд гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг авсан байна. Харин 2021, 2022 онд гүйцэтгэгч компанийн эзэмшигч тодорхойгүй нөхцөл байдал үүссэний улмаас ажил нь зогссон учраас санхүүжилт аваагүй, 2023 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй байна. Тус ажилд 2022 онд ҮАГ-тай гэрээ байгуулсан шинжээч ирж ажилласан байна.

Түүнчлэн 2019 оноос дамжин хэрэгжиж байгаа 2023 оны төсвийн тухай хуульд батлагдсан 1 төсөл, арга хэмжээний хүрээнд 2023 онд ямар нэгэн ажил хийгдээгүй, санхүүжилтийг олгоогүй байна.

- 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2019-2023 онд хэрэгжүүлэх Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/, тендерт МА3 ХХК шалгарч 2019 онд 1,917.3 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. 2020 оны 07 дугаар сарын 20-нд 91.8 хувийн гүйцэтгэл батлуулж 1,759.2 сая төгрөгийн санхүүжилт авсан. Соёмбот зам ХХК зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж хяналт тавьж байсан байна. Одоо байгаа бодит гүйцэтгэлийг аймгийн ГХБХБГ-ын хяналтын инженер 78% гэж дүгнэж байна. 2023 оны төсвийн тухай хуульд УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолын хүрээнд үнийн өсөлтийн 22.5 сая төгрөг тусгагдсан ба үлдэгдэл санхүүжилт нь тусгагдаагүй. 2023 онд ажил хийгдээгүй санхүүжилт аваагүй орхигдсон байна.

Цаашид дээрх он дамжин дуусаагүй ажлуудыг холбогдох төсвийн Ерөнхийлөн захирагчдад санал хүргүүлж шийдвэрлүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн 3 төсөл, арга хэмжээнд нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан байна.

- Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/
- Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/
- Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/

Хүснэгт 4. Нэмэлтээр байгуулсан гэрээний мэдээллийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн		Олгосон санхүүжилт
			Анхны /сая.төг/	Сүүлийн /сая.төг/	
1	X.1.1.45	Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/	3,892.4	5,117.2	4,589.7
2	X.2.1.3	Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	4,473.0	6,804.8	6,123.8
3	XII.2.1.14	Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/	298.7	576.5	516.5

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/-ын нэмэлт ажил болох гадна спорт чийрэгжүүлэлтийн талбайн ажлыг Барилгын хөгжлийн төвийн 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 1429/2023 дугаар магадлалын дүгнэлт, 2023 оны төсвийн тухай хуулийг үндэслэн гүйцэтгэгч Ундарга констракшн ХХК-тай нэмэлт гэрээг байгуулсан байна.

Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/-ийн нэмэлт ажлыг Барилгын хөгжлийн төвийн 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 1077/2023 дугаар магадлалын дүгнэлт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/366 тушаал, 2023 оны төсвийн тухай хуулийг үндэслэн гүйцэтгэгч Амарсанаа ХХК-тай нэмэлт гэрээг байгуулсан байна.

Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/-ийн барих ажлыг Барилгын хөгжлийн төвийн 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 238/2022 дугаар магадлалын дүгнэлт, 2023 оны төсвийн тухай хуулийг үндэслэн гүйцэтгэгч Боб энерги констракшн ХХК-тай нэмэлт гэрээг байгуулсан байна.

Анхны тендерт шалгарсан үнийн дүн дээр магадлалаар нэмэгдсэн төсөвт өртгийг нэмж гэрээ байгуулах байсан ч 2 төсөл, арга хэмжээнд тендерийн хэмнэлтийг хасаж тооцохгүйгээр 2023 онд нэмэлт гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 5. Тендерийн хэмнэлтийг хасаж тооцохгүйгээр гэрээ байгуулсан мэдээлэл

№	Төсөл, арга хэмжээний нэр	Анхны төсөвт өртөг /сая.төг/	Анхны гэрээний дүн /сая.төг/	Тендерийн хэмнэлт /сая.төг/
1	Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	4,474.0	4,473.0	1.0
2	Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/	300.0	298.7	1.3

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Иймд дээрх 2 төсөл, арга хэмжээний гэрээг шинэчлэн байгуулж тендерийн хэмнэлтийг үлдэгдэл санхүүжилтээс суутган тооцохыг зөвлөмж болголоо.

Тухайн үед мөрдөгдөж байсан Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.3.4.2-т “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төслийн нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” гэж заасан шаардлагыг хангаагүй 5 төсөл арга хэмжээг 2023 оны төсвийн тухай хуульд тусгасан байна.

Хүснэгт 6. Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний мэдээлэл

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг (сая.төг)	2023 онд санхүүжих дүн (сая.төг)	Хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилсан дүн (сая.төг)	Зөрүү (сая.төг)
1	X.1.1.236	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Завхан сум/	2022	2024	7,324.70	2,227.60	2,441.6	(214.0)
2	X.1.1.315	Сургуулийн барилга, 960 суудал /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/	2022	2024	11,000.00	2,622.20	3,666.7	(1,044.5)
3	XIII.1.21	Загвар хоршоо	2022	2024	2,978.40	944.2	992.8	(48.6)
4	XIII.1.28	Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/	2022	2024	2,311.00	450	770.3	(320.3)
5	XIII.1.20	Үр тариа хадгалах агуулах /Увс, Дорнод/	2022	2024	4,930.80	1,049.80	1,643.6	(593.8)

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх 6 төсөл арга хэмжээнд нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс 48.6 – 1,044.5 сая төгрөгийг дутуу хуваарилсан байна. Иймд тус асуудлыг холбогдох албан тушаалтнууд анхаарч батлагдсан журмыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.6 дахь заалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэж заажээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн 19 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн дагуу санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 7. 2023 оны төсвийн тухай хуульд эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг дараах байдлаар тусгасан байна.

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг /сая.төг/	2023 онд санхүүжих дүн /сая.төг/
IX.1.27	Нийтийн эзэмшлийн орон сууцын байруудын гадна фасад, дулаалгын засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	2020	2023	1,522.6	194.1
IX.1.43	Нийтийн эзэмшлийн орон сууцын байруудын дээврийн засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	2020	2023	1,191.3	361.3
X.1.1.146	Сургуулийн спорт заалны барилга /Увс, Сагил сум/	2020	2023	1,456.4	217.6
X.1.1.156	Дотуур байрны барилга, 100 ор /Увс, Ховд сум/	2020	2023	2,401.4	517.7
X.1.1.161	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Увс, Тэс сум/	2020	2023	5,021.6	823.9
X.1.1.45	Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/	2019	2024	5,129.0	697.2
X.2.1.3	Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	2019	2023	6,804.8	435.0
XI.1.20	Аймгийн хөгжимт драмын “Ойрад” театрын барилга /Увс, Улаангом сум/	2019	2023	10,813.7	3,056.2
XII.1.1.15	Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/	2019	2023	1,939.8	22.5
XII.1.1.36	Сумын төвөөс Хархираа баг хүртэлх сайжруулсан шороон зам, 25 км /Увс, Тариалан сум/	2020	2023	205.5	10.8
XII.1.1.79	3 дугаар 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар- "ТНХ" ХХК-ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл /Увс, Улаангом сум/	2022	2023	2,000.0	1,990.0
XII.1.4.4	Баруун 4 замын уулзварын өргөтгөл, 3 дугаар 10 жилийн тойрог хүртэлх авто замын шинэчлэлийн зураг төсөв /Увс, Улаангом сум/	2022	2023	74.2	64.2
XII.2.1.14	Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/	2022	2023	576.5	516.5

XII.2.1.17	Баруун гол дээр баригдах замын байгууламж /Увс, Өлгий сум/	2022	2023	288.9	228.9
XIII.1.21	Загвар хоршоо	2022	2024	2,978.4	944.2
XIII.1.28	Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/	2022	2024	2,311.0	450.0
XIII.3.16	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/	2021	2024	4,500.0	1,000.0
XIX.1.15	Спорт цогцолборын барилга /Увс, Тариалан сум/	2020	2023	1,463.7	314.1
XV.1.10	Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ор /Увс, Улаангом сум/	2019	2023	4,966.8	127.5

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх эрх шилжсэн 19 төсөл, арга хэмжээнээс 2021-2022 онд хэрэгжиж дууссан Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолд үндэслэн Барилга, хот байгуулалтын яамнаас баталгаажуулсан барилгын материалын үнийн өсөлтөөс үүдсэн төсөвт өртгийг нэмэгдүүлсэн 8 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 2023 оны төсвийн хуульд тусгаж баталсан байна.

Хүснэгт 8. Үнийн өсөлтийн нэмэлт санхүүжилт олгосон төсөл, арга хэмжээ, санхүүжилтийн дүнг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах огноо	Төсөвт өртөг /сая.төг/	2023 онд санхүүжих дүн /сая.төг/	Үнийн өсөлт авсан санхүүжилт /сая.төг/	Үнийн өсөлтийн магадлалын дүгнэлтийн огноо, дугаар
IX.1.27	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын гадна фасад, дулаалгын засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	2020-2023	1,522.6	194.1	194.1	2022.06.18 №ЕД88-0163/2022
IX.1.43	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	2020-2023	1,191.3	361.3	361.3	2022.06.11 №88-0106/2022
X.1.1.146	Сургуулийн спорт заалны барилга /Увс, Сагил сум/	2020-2023	1,456.4	217.6	217.6	2022.06.17 №88-199/2022
X.1.1.156	Дотуур байрны барилга, 100 ор /Увс, Ховд сум/	2020-2023	2,401.4	517.7	517.7	2022.06.09 №88-0014/2022
X.1.1.161	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Увс, Тэс сум/	2020-2023	5,021.6	823.9	823.9	2022.06.09 №88-0018/2022
XII.1.1.36	Сумын төвөөс Хархираа баг хүртэлх сайжруулсан шороон зам, 25 км /Увс, Тариалан сум/	2020-2023	205.5	10.8		аваагүй
XIX.1.15	Спорт цогцолборын барилга /Увс, Тариалан сум/	2020-2023	1,463.7	314.1	314.1	2022.06.15 №88-090/2022
XV.1.10	Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ор /Увс, Улаангом сум/	2019-2023	4,966.8	127.5	124.4	2022.06.15 №88-0291/2022
Дүн			18,229.3	2567.0	2,553.0	

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх үнийн өсөлтөөс үүдсэн төсөвт өртгийг нэмэгдүүлэн олгосон 8 төсөл арга хэмжээнээс 7 гүйцэтгэгч байгууллагад санхүүжилтийг бүрэн олгож, 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч компани санхүүжилт аваагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн эрх шилжиж ирсэн 19 төсөл, арга хэмжээнээс 13,623.2 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг комисс ашиглалтад хүлээн авсан ба 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгож, 2 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, 1 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг 2024 оны төсвийн тухай хуульд тусгасан байна.

Хүснэгт 9. Тайлант онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний хугацаа	Гэрээний дүн /сая.төг/	Ажил эхэлснээс хойш олгосон нийт санхүүжилт /сая.төг/	Тайлбар
1	X.1.1.45	Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/	2019.06.07-2023.12.25	5,117.2	4,589.6	Хэрэгжиж дууссан санхүүжилт дутуу үлдсэн
2	X.2.1.3	Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	2019.10.01-2023.12.25	6,804.7	6,123.7	Хэрэгжиж дууссан санхүүжилт дутуу үлдсэн
3	XII.1.4.4	Баруун 4 замын уулзварын өргөтгөл, 3 дугаар 10 жилийн тойрог хүртэлх авто замын шинэчлэлийн зураг төсөв /Увс, Улаангом сум/	2022.06.02-2022.09.30	74.2	74.2	Бүрэн хэрэгжсэн
4	XII.2.1.14	Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/	2022.05.04-2023.12.30	576.5	516.5	Хэрэгжиж дууссан санхүүжилт дутуу үлдсэн
5	XII.2.1.17	Баруун гол дээр баригдах замын байгууламж /Увс, Өлгий сум/	2022.05.09-2023.12.25	288.5	228.5	Бүрэн хэрэгжсэн
6	XII.1.4.4	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга багц2 /Увс/	2022.04.13-2022.12.15	179.4	176.4	Бүрэн хэрэгжсэн
7	XIII.3.16	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 1 буюу "Үхрийн үүлдэр угсааг сайжруулах"	2023.03.13-2023.05.30	149.9	149.9	Бүрэн хэрэгжсэн
		Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц2 буюу "Хүлэмж болон түүнд шаардлагатай тоног төхөөрөмж"	2023.04.26-2023.06.26	239.9	239.9	Бүрэн хэрэгжсэн
		Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 3 буюу "Цахим сургалтын тоног төхөөрөмж" (19 сумын ЕБС)	2023.03.13-2023.07.30	279.7	279.7	Бүрэн хэрэгжсэн

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 2 буюу "Хүлэмж болон түүнд шаардлагатай тоног төхөөрөмж" төсөл арга хэмжээний хүрээнд 100 ширхэг хүлэмж худалдан авч Увс аймгийн Засаг даргын тамгын газрын цахим

хуудаст хүлэмжийг хариуцан менежментийн гэрээгээр ашиглах сонгон шалгаруулалтын урилга байршуулж сонирхсон иргэд, аж ахуйн нэгжээс баримт материал хүлээн авсан байна. Сонгон шалгаруулалтын хүрээнд 197 иргэн, аж ахуйн нэгж баримт материал ирүүлсэн байна. Аймгийн Засаг даргын 2023 оны А/188 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ирүүлсэн баримт материалуудыг үнэлж 5 ширхэг хүлэмжийг төрийн байгууллагад шилжүүлж, 9 ширхэг хүлэмжийг аж ахуйн нэгжид, 86 ширхэг хүлэмжийг иргэдэд олгож гэрээгээр ашиглуулж байна. 4 ширхэг хүлэмжийг тухайн төрийн байгууллагын, 84 ширхэг хүлэмжийг аймгийн Засаг даргын тамгын газар, 12 ширхэг хүлэмжийг сумдын Засаг даргын тамгын газрын данс бүртгэлд тусгасан байна.

Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдсэн иргэн аж ахуйн нэгжид гэрээгээр үнэ төлбөргүй ашиглуулж байгаа хүлэмжийг түрээсээр ашиглуулах асуудлыг судалж шийдвэрлэхийг зөвлөмж болголоо.

Эрх шилжсэн хэрэгжиж дуусаагүй 6 төсөл, арга хэмжээнээс он дамжин хэрэгжих 2, хугацаандаа хэрэгжээгүй 4 төсөл арга хэмжээ байна.

Хүснэгт 10. Гүйцэтгэл дутуу он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Гэрээний эхлэх, дуусах огноо	Ажил эхэлснээс хойш олгосон нийт санхүүжилт /2023 оныг оруулсан дүн/ /сая.төг/	2023 онд олгосон санхүүжилт /сая.төг/	Хэрэгжиж дууссан эсэх /тийм, үгүй, хугацаа болоогүй/	Хэрэгжиж дуусаагүй ТАХ-ны шалтгаан, нөхцөл
XI.1.20	Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/	10,813.7	2019.09.27-2023.12.30	10,272.9	2,508.9	үгүй	Хугацаандаа ажлаа хийж гүйцэтгээгүй
XII.1.1.15	Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/	1,939.8	2019.06.05-2022.07.25	1,759.2	0.0	үгүй	Гүйцэтгэгчээс хамааралтай
XII.1.1.79	3 дугаар 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар-"ТНХ" ХХК-ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл /Увс, Улаангом сум/	2,000.0	2022.06.24-2024.07.01	1,092.0	1,082.0	Үгүй	Хугацаандаа ажлаа хийж гүйцэтгээгүй
XIII.1.21	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга багц1 Увс/ Цагаан ултай гутлын кластер төвийн барилга /Улаангом/	2,978.4	2022.04.13-2024.06.30	1,853.2	944.2	Хугацаа болоогүй	
XIII.1.28	Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/	2,311.0	2023.05.04-2024.12.30	450.0	450.0	Хугацаа болоогүй	
XIII.3.16	Орон нутгийн хөгжлийг дэмжих	250.0	2023.06.13-2023.12.20	147.1	147.1	Үгүй	Гүйцэтгэгч тоног төхөөрөмж бүрэн

	"Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 4 буюу "Тэс суманд шаардлагатай тоног төхөөрөмж"						хүлээлгэж өгөөгүй
	Нийт дүн	20,292.9		15,574.5	5,132.2		

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Нийт 4 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 2,232.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Хүснэгт 11. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл, арга хэмжээний мэдээлэл:

Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Барьцаа хөрөнгийн данс	Барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа дүн /сая.төг/
Х.2.1.3	Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	Ув.БШУС-ын ЭШХО Төрийн сан	681.0
ХIII.3.16	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 4 буюу "Тэс суманд шаардлагатай тоног төхөөрөмж"	Ув.ХХААХҮС-ын ЭШХО Төрийн сан	102.4
ХII.1.1.79	3 дугаар 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар- "ТНХ" ХХК-ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл /Увс, Улаангом сум/	Ув.ЗТХСайд ЭШХО Төрийн сан	908.0
ХI.1.20	Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/	Ув.Сангийн сайдын ЭШХО Төрийн сан	540.7
Нийт дүн			2,232.0

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Үүнээс "Политехник коллеж оюутны дотуур байрны 300 ортой барилга"-ыг комисс хүлээн авсан ч өгсөн үүрэг даалгавар хэрэгжээгүй, гүйцэтгэлийг баталгаажуулаагүй байсан тул үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

"Шинэ хөдөө" төслийн 4 дүгээр багц, "3 дугаар 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар- "ТНХ" ХХК-ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл", "Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилгын ажил"-ын гүйцэтгэлээс шалтгаалан үлдэгдэл санхүүжилтийг Засгийн газрын 2023 оны 466 дугаар тогтоолыг үндэслэн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

**БҮЛЭГ: Б. Эрх шилжээгүй 8, эрх шилжсэн 4 хөрөнгө оруулалтын
төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь гүйцэтгээгүй байна.**

Б.1 Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуульд Увс аймагт хэрэгжихээр батлагдсан 46 төсөл, арга хэмжээнээс эрх шилжээгүй 27, эрх шилжиж ирсэн 19 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 2021, 2022 онд хэрэгжиж дууссан 12 төсөл, арга хэмжээ, 2023 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн 25 төсөл арга хэмжээ, он дамжин хэрэгжихээр төлөвлөсөн 8 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 12. Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан 2021, 2022 онд хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний мэдээллийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

/сая.төг/

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	2023 оны төсвийн тухай хуульд	Хүлээн авсан актын огноо	Тайлбар
1	IX.1.27	Нийтийн эзэмшлийн орон сууцын байруудын гадна фасад, дулаалгын засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	194.1	2021.10.06	УИХ-ын 2021 оны 88-р тогтоол
2	IX.1.43	Нийтийн эзэмшлийн орон сууцын байруудын дээврийн засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	361.3	2022.12.14	УИХ-ын 2021 оны 88-р тогтоол
3	X.1.1.146	Сургуулийн спорт заалны барилга /Увс, Сагил сум/	217.6	2022.01.28	УИХ-ын 2021 оны 88-р тогтоол
4	X.1.1.156	Дотуур байрны барилга, 100 ор /Увс, Ховд сум/	517.7	2022.12.12	УИХ-ын 2021 оны 88-р тогтоол
5	X.1.1.161	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Увс, Тэс сум/	823.9	2022.07.03	УИХ-ын 2021 оны 88-р тогтоол
6	X.1.1.188	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл 50 ор, их засвар /Увс, Давст сум/	109.1	2022.12.08	УИХ-ын 2021 оны 88-р тогтоол
7	X.1.2.5	Дотуур байрны барилгын их засвар /Увс, Хяргас сум/	186.6	2022.11.23	УИХ-ын 2021 оны 88-р тогтоол
8	XII.1.1.36	Сумын төвөөс Хархираа баг хүртэлх сайжруулсан шороон зам, 25 км /Увс, Тариалан сум/	10.8	2021.11.30	УИХ-ын 2021 оны 88-р тогтоол
9	XII.1.4.4	Баруун 4 замын уулзварын өргөтгөл, 3 дугаар 10 жилийн тойрог хүртэлх замын шинэчлэлийн зураг төсөв /Увс, Улаангом сум/	64.2	2022.09.28	Үлдэгдэл санхүүжилт
10	XIX.1.15	Спорт цогцолборын барилга /Увс, Тариалан сум/	314.1	2022.09.22	УИХ-ын 2021 оны 88-р тогтоол
11	XV.1.10	Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ор /Увс, Улаангом сум/	127.5	2021.11.25	УИХ-ын 2021 оны 88-р тогтоол

12	XV.1.43	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар /Увс, Наранбулаг сум/	169.6	2022.12.06	УИХ-ын 2021 оны 88-р тогтоол
----	---------	---	-------	------------	------------------------------

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх төсөл, арга хэмжээнүүд өмнөх онуудад бүрэн хэрэгжиж дууссан ба УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолын хүрээнд үнийн өсөлтийн санхүүжилт, үлдэгдэл санхүүжилтээ авсан байна.

Хүснэгт 13. 2023 онд хэрэгжүүлж дуусгахаар төсвийн тухай хуульд заасан 25 төсөл, арга хэмжээ, төсвийн тухай хуульд 2024 онд дуусахаар тусгасан ч 2023 онд олгосон санхүүжилтийн хүрээнд хэрэгжсэн 1 төсөл, арга хэмжээ нийт 26 төсөл, арга хэмжээний мэдээллийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Сумын нэр	Эрх шилжсэн эсэх	Төсөвт өртөг сая.төг	Олгосон санхүүжилт /хувь/	Хүлээн авсан актын огноо
1	IV.1.13	Цөлжилттэй тэмцэх ногоон байгууламж /Увс, Улаангом сум/	Улаангом	Үгүй	359.8	100%	2022.07.06 2023.11.17
2	IX.1.111	Сумын төвийн тохижилт /Увс, Зүүнхангай, Ховд, Хяргас, Өндөрхангай, Малчин сум/	Зүүнхангай	Үгүй	4,751.1	100%	2023.12.07
			Ховд	Үгүй		100%	2023.12.04
			Хяргас	Үгүй		91%	-
			Өндөрхангай	Үгүй		100%	2023.11.17
			Малчин	Үгүй		51%	-
3	IX.1.117	Сумын төвийн тохижилт /Увс, Наранбулаг, Завхан сум/	Наранбулаг	Үгүй	1,976.0	100%	2023.12.14
			Завхан	Үгүй		100%	2023.11.21
4	IX.1.60	Ухаалаг худаг бүхий нийтийн халуун усны барилга /Увс, Зүүнхангай сум/	Зүүнхангай	Үгүй	395.6	87%	-
5	IX.1.61	Сумын төвийн тохижилт /Увс, Түргэн сум/	Түргэн	Үгүй	1,383.4	55%	-
6	IX.1.69	Сумын төвийн тохижилт /Увс, Улаангом сум/	Улаангом 1-р баг	Үгүй	7,935.0	100%	2023.11.08
			Улаангом 2-р баг	Үгүй		100%	2022.12.21
			Улаангом 3-р баг	Үгүй		100%	2022.12.14
			Улаангом 4-р баг	Үгүй		100%	2023.11.08

			Улаангом 5-р баг	Үгүй		100%	2023.12.15
			Улаангом 6-р баг	Үгүй		100%	2023.12.15
			Улаангом 7-р баг	Үгүй		87.5%	-
			Улаангом 9-р баг	Үгүй		100%	2023.07.21
			Улаангом 10-р баг	Үгүй		100%	2023.10.27
			Улаангом 11-р баг	Үгүй		100%	2023.10.16
			Улаангом 12-р баг	Үгүй		87.4%	-
7	IX.1.87	Сум, багийн орчныг тохижуулах "Шинэ гудамж" төсөл /Увс, Улаангом сум/	Улаангом	Үгүй	953.6	100%	2023.12.25
8	IX.4.3	Сумын төвийн гэр хорооллын инженерийн дэд бүтцийн зураг төсөв /Увс, Давст, Түргэн, Наранбулаг сум/	3 сум	Үгүй	593.8	100%	
9	VI.1.1.1	Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилга /Увс, Улаангом сум/	Улаангом	Үгүй	1,868.4	73.7%	
10	VII.1.1.1	Архивын барилга /Увс, Улаангом сум/	Улаангом	Үгүй	2,856.6	100%	2023.08.08
11	X.1.1.206	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Увс, Улаангом сум, 6 дугаар баг, 8 дугаар цэцэрлэг/	Улаангом	Үгүй	1,045.0	100%	2023.06.26
12	X.1.1.235	Сургуулийн дотуур байрны шинэчлэл, тохижилт /Увс, Ховд сум/	Ховд	Үгүй	1,000.0	100%	2023.10.01
13	X.1.1.313	Дотуур байрны барилга, 100 ор /Увс, Наранбулаг сум/	Наранбулаг	Үгүй	2,859.9	90%	

14	X.2.1.3	Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	Улаангом	Тийм	6,804.8	100%	2023.12.15
15	XI.1.20	Аймгийн хөгжимт драмын “Ойрад” театрын барилга /Увс, Улаангом сум/	Улаангом	Тийм	0,813.7	95%	
16	XII.1.1.15	Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/	Улаангом	Тийм	1,939.8	91.8%	
17	XII.1.1.79	3 дугаар 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар-“ТНХ” ХХК-ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл /Увс, Улаангом сум/	Улаангом	Тийм	2,000.0	54.6%	
18	XII.1.4.2	Увс нуур-Улаангом чиглэлийн 25.84 км хатуу хучилттай авто замын зураг төсөв /Увс, Улаангом сум/	Улаангом	Үгүй	357.5	100%	
19	XII.2.1.14	Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/	Цагаанхайрхан	Тийм	576.5	100%	2023.12.14
20	XII.2.1.17	Баруун гол дээр баригдах замын байгууламж /Увс, Өлгий сум/	Өлгий	Тийм	288.9	100%	2023.06.23
21	XIII.1.16	Арсайн газар тариалангийн услалтын систем /Увс, Улаангом сум/	Улаангом	Үгүй	2,574.0	44.1%	
22	XIII.3.16	Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Увс/ багц 1 буюу “Үхрийн	19 сум	Тийм	4,500.0	100%	2023.04.18

		үүлдэр угсааг сайжруулах”					
		Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц2 буюу “Хүлэмж болон түүнд шаардлагатай тоног төхөөрөмж”	Улаангом	тийм		100%	2023.06.07
		Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 3 буюу “Цахим сургалтын тоног төхөөрөмж” (19 сумын ЕБС)	19 сум	тийм		100%	2023.07.06
		Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 4 буюу “Тэс суманд шаардлагатай тоног төхөөрөмж”	Тэс	тийм		59%	
23	XIX.1.20	Спорт заалны барилга /Увс, Хяргас сум/	Хяргас	Үгүй	2,535.8	98.9%	2023.12.12
24	XIX.1.23	Спорт заалны барилга /Увс, Малчин сум/	Малчин	Үгүй	1,394.7	67.1%	
25	XV.1.60	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Увс, Давст сум/	Давст	Үгүй	1,142.1	100%	2023.12.11
26	XVI.1.2	Прокурорын газрын барилга /Увс, Улаангом сум/	Улаангом	Үгүй	2,821.6	100%	

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2023 онд хэрэгжиж дуусахаар батлагдсан ч дуусаагүй 12 төсөл, арга хэмжээнээс эрх шилжиж ирээгүй 8 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- Сумын төвийн тохижилт /Увс, Зүүнхангай, Ховд, Хяргас, Өндөрхангай, Малчин сум/ 5 багцад задарснаас Хяргас Малчин сум
- Сумын төвийн тохижилт Улаангом сум 11 багцад задарснаас 7,12 дугаар багуудын ажил
- Сумын төвийн тохижилт /Увс, Түргэн сум/
- Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилга
- Ухаалаг худаг бүхий нийтийн халуун усны барилга /Увс, Зүүнхангай сум/
- Дотуур байрны барилга, 100 ор /Увс, Наранбулаг сум/
- Арсайн газар тариалангийн услалтын систем
- Спорт заалны барилга /Увс, Малчин сум/

Дээрх 26 төсөл, арга хэмжээнээс эрх шилжин хэрэгжсэн 7 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 14. Эрх шилжин хэрэгжсэн 7 төсөл, арга хэмжээний мэдээлэл.

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Сумын нэр	Төсөвт өртөг сая.төг	Олгосон санхүүжилт сая.төг	Олгосон санхүүжилт хувь	Хүлээн авсан актын огноо
1	X.2.1.3	Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	Улаангом	6,804.8	6804.8	100.0	2023.12.15
2	XI.1.20	Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/	Улаангом	10,813.7	10,272.9	95.0	
3	XII.1.1.15	Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/	Улаангом	1,939.8	1,759.2	91.8	
4	XII.1.1.79	3 дугаар 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар- "ТНХ" ХХК-ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл /Увс, Улаангом сум/	Улаангом	2,000.0	1092.0	54.6	
5	XII.2.1.14	Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/	Цагаанхайрхан	576.5	576.5	100.0	2023.12.14
6	XII.2.1.17	Баруун гол дээр баригдах замын байгууламж /Увс, Өлгий сум/	Өлгий	288.9	288.5	100.0	2023.06.23
7	XIII.3.16	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 1 буюу "Үхрийн үүлдэр угсааг сайжруулах"	19 сум	150.0	149.9	100.0	2023.04.18
		Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц2 буюу "Хүлэмж болон түүнд шаардлагатай"	Улаангом	300.0	239.9	100.0	2023.06.07

	тоног төхөөрөмж"					
	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 3 буюу "Цахим сургалтын тоног төхөөрөмж" (19 сумын ЕБС)	19 сум	300.0	279.7	100.0	2023.07.06
	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 4 буюу "Тэс суманд шаардлагатай тоног төхөөрөмж"	Тэс	250.0	147.1	59.0	

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2023 онд хэрэгжиж дуусахаар батлагдсан ч дуусаагүй эрх шилжиж ирсэн 4 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга
- Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/
- 3 дугаар 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар- "ТНХ" ХХК-ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл
- Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 4 буюу "Тэс суманд шаардлагатай тоног төхөөрөмж"

Дээрх гэрээний хугацаанд дуусаагүй төсөл арга хэмжээг гүйцэтгэгчээр ажлыг хийлгэж хүлээн авахыг зөвлөмж болгов.

Хүснэгт 15. Он дамжин хэрэгжихээр төлөвлөсөн 8 төсөл, арга хэмжээний мэдээллийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эрх шилжсэн эсэх	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг (сая.төг)	2023 онд санхүүжих дүн (сая.төг)
1	X.1.1.236	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Завхан сум/	Үгүй	2022	2024	7,324.7	2,227.6
2	X.1.1.284	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Хяргас сум/	Үгүй	2022	2024	7,342.9	3,429.6
3	X.1.1.315	Сургуулийн барилга, 960 суудал /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/	Үгүй	2022	2024	11,000.0	2,622.2
4	X.1.1.45	Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/	Тийм	2019	2024	5,129.0	697.2
5	XIII.1.21	Загвар хоршоо	Тийм	2022	2024	2,978.4	944.2
6	XIII.1.28	Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/	Тийм	2022	2024	2,311.0	450.0
7	XIII.3.16	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл	Тийм	2021	2024	4,500.0	1,000.0

		/Увс/					
8	XIII.1.20	Үр тариа хадгалах агуулах /Увс, Дорнод/	Үгүй	2022	2024	4,930.8	1,049.8

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

- Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/ улсын комисс 2023 онд байнгын ашиглалтад хүлээн авсан байна.
- Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга /Увс/ 2 багцад задарсан. Багц 1 буюу Цагаан Ултай гутлын кластер төвийн барилга /Улаангом/ барилгын ажил явагдаж байна. Багц 2 Сүү, Цагаан идээ боловсруулах цехийн барилга /Сагил/ улсын комисс 2022 онд байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

Б.2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.1 дэх заалтад “Нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих”, 35.1.4 дэх заалтад “Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах”, 35.1.6 дахь заалтад “Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах”, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ, 37.1.4 дэх заалтад “Барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах”, 37.1.9 дэх заалтад “Барилгын үйл ажиллагаанд холбогдох барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж холбогдох зардлыг хариуцах” гэж заажээ.

Мөн тухайн үед мөрдөгдөж байсан Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.1-д “Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгүүлж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ”, 5.2.2 дахь заалтад “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4-т “Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг”, 4.4.1.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилжүүлсэн эрхийн дагуу захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг төсөл, арга хэмжээ тус бүрээр захиалагчтай байгуулах” гэж заасан байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас аймгийн Засаг даргатай 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан №01/20 дугаартай гэрээний дагуу хэрэгжүүлэн ажилласан байна.

Ингэхдээ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу ил далд ажлын актаар баталгаажуулж, гэрээний хугацаанд гүйцэтгүүлэх талаар зөвлөмж чиглэл өгсөн байна. Мөн гүйцэтгэл нь дууссан төсөл, арга хэмжээ бүрд улсын комисс ажиллуулах Засаг даргын захирамж гарч ашиглалтад хүлээн авсан байна.

Түүнчлэн улсын төсвийн эрх шилжиж ирээгүй 19 төсөл, арга хэмжээнд Барилга хөгжлийн төвийн захирал аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргатай 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн “Аймагт хэрэгжүүлэх барилга, байгууламжийн ажилд захиалагчийн техникийн хяналт гүйцэтгүүлэх гэрээ”-г байгуулж захиалагчийн хяналт тавиулж байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.5 дахь заалтад “Барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах”, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Зураг төсөл зохиогч дараах чиг үүрэгтэй”, 38.1.3 дахь заалтад “Зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх”, 38.1.4 дэх заалтад “Зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх”, 38.1.8 дахь заалтад “Барилгын ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авахыг захиалагчаас шаардах”, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.1-д “Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина”, 3.3-д “Зохиогчийн хяналт гүйцэтгэх хэлбэрийг зураг төсөл зохиогч, захиалагч, барилгын ажил гүйцэтгэгч тохиролцож гэрээгээр зохицуулна”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.5-д “Зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг”, 4.5.1-т “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэгч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 4.5.1.1-т “Төсөл, арга хэмжээний зураг төсвийн зохиогч нь төслийг хэрэгжүүлэхэд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд Барилгын тухай хууль, “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-д заасны дагуу “Төсөл, арга хэмжээ тус бүрээр захиалагчтай гэрээ байгуулах” гэж заасны дагуу зохиогчийн хяналтыг зураг төсөв боловсруулсан байгууллага захиалагчтай гэрээ байгуулан гүйцэтгэж байна.

Барилгын тухай хууль 48 дугаар зүйл “Барилга байгууламж ашиглалтад оруулах” 48.1 дэх хэсэгт “Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна”, Авто замын тухай хуулийн 28 дугаар зүйлд “Авто зам, замын байгууламжийг ашиглалтад

оруулах” 28.1 дэх хэсэгт “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замыг ашиглалтад авах асуудлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах асуудлыг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна”, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 8.2-т “Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн 8.1-д заасан хугацаанд багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 8.2.1-д “Барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж дүгнэлт гарган барилга байгууламжийг ашиглалтад оруулсан байна.

Байнгын ашиглалтад хүлээн авсан 8 төсөл, арга хэмжээнд улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт бүрэн хангагдаагүй байна.

Хүснэгт 16. Байнгын ашиглалтад хүлээн авсан 8 төсөл, арга хэмжээний мэдээлэл.

№	Хуулийн код	Төсөл арга хэмжээний нэр	Биелэгдээгүй үрэг даалгаврын тоо	Тайлбар
Үгүй	IV.1.13	Цөлжилттэй тэмцэх ногоон байгууламж /Увс, Улаангом сум/	1	
1	IX.1.111	Сумын төвийн тохижилт Ховд	6	
		Сумын төвийн тохижилт Өндөрхангай	5	нэмэлт гэрээ байгуулсан
2	IX.1.117	Сумын төвийн тохижилт Наранбулаг	7	
		Сумын төвийн тохижилт Завхан	4	
3	IX.1.69	Сумын төвийн тохижилт Улаангом 10 дугаар баг	2	
		Сумын төвийн тохижилт Улаангом 11 дүгээр баг	2	
4	IX.1.87	Сум, багийн орчныг тохижуулах "Шинэ гудамж" төсөл /Увс, Улаангом сум/	3	нэмэлт гэрээ байгуулсан
5	X.1.1.45	Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/	3	
6	X.2.1.3	Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	5	нэмэлт гэрээ байгуулсан
7	XII.2.1.14	Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/	4	
8	XIX.1.20	Спорт заалны барилга /Увс, Хяргас сум/	1	

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж ажиллахыг холбогдох байгууллагад зөвлөмж болголоо.

Б.3. Хэрэгжүүлж дууссан 10 төсөл, арга хэмжээг Төрийн өмчийн хорооны шийдвэр ирээгүйгээс данс бүртгэлд тусгаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасан ч ашиглалтад орсон Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээнүүдийг Төрийн өмчийн хорооны шийдвэр ирээгүйгээс данс бүртгэлд тусгаагүй байна.

Хүснэгт 17. Бүртгэлд тусгаагүй төсөл, арга хэмжээний мэдээлэл

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг (сая.төг)
1	IV.1.13	Цөлжилттэй тэмцэх ногоон байгууламж /Увс, Улаангом сум/	359.8
2	IX.1.111	Сумын төвийн тохижилт /Увс, Зүүнхангай, Ховд, Хяргас, Өндөрхангай, Малчин сум/	4,751.1
3	IX.1.117	Сумын төвийн тохижилт /Увс, Наранбулаг, Завхан сум/	1,976.0
4	IX.1.69	Сумын төвийн тохижилт /Увс, Улаангом сум/	7,935.0
5	IX.1.87	Сум, багийн орчныг тохижуулах "Шинэ гудамж" төсөл /Увс, Улаангом сум/	953.6
6	X.1.2.5	Дотуур байрны барилгын их засвар /Увс, Хяргас сум/	886.6
7	X.2.1.3	Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	6,804.8
8	XIX.1.20	Спорт заалны барилга /Увс, Хяргас сум/	2,535.8
9	XV.1.43	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар /Увс, Наранбулаг сум/	994.6
10	XV.1.60	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Увс, Давст сум/	1,142.1

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Иймд дээрх барилгуудыг тухайн ашиглагч байгууллагын хөрөнгийн бүртгэлд тусгах асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэхийг зөвлөмж болголоо.

БҮЛЭГ:В. Хэрэгжсэн 3 төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд бүрэн хүрээгүй байна.

В.1. Хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж эхлээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн улсын комисс ашиглалтад хүлээж авсан Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/ ашиглагдаж эхлээгүй байна.

Улсын комисс тус барилгыг 2023 оны 12 дугаар сарын 15-нд хүлээн авсан байна. Дотуур байранд суралцагчдыг байрлуулахад шаардлагатай ор, сандал, ширээ болон бусад хатуу зөөлөн эдлэл байхгүйгээс шалтгаалан ашиглаж эхлээгүй байна. Улаангом политехник коллежийн удирдлагын зүгээс Боловсролын ерөнхий газарт албан бичгээр болон биечлэн удаа дараа хандсан боловч мэргэжлийн боловсролын салбарт хөрөнгө оруулалтын санхүүжилт төлөвлөгдөөгүй гэсэн шалтгаанаар шийдвэрлэж өгөөгүй гэсэн тайлбарыг ирүүлсэн.

Улаангом политехник коллежийн удирдлагаас 300 ортой дотуур байрны тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын жагсаалт, тооцоог гаргаж 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 1/50, 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 1/52 дугаар албан бичгүүдээр Боловсролын ерөнхий газар, Хөрөнгө оруулалтын хэрэгжилт зохицуулалтын газарт хандсан байна.

Одоо ашиглаж байгаа 100 хүүхдийн дотуур байрны тавилга хэрэгсэл нь хуучирч чанарын шаардлага хангахгүй болсон. Мөн тооны хувьд хүрэлцэхгүй тул шилжүүлэн ашиглах боломжгүй байна.

Иймд дотуур байрны барилгыг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглахын тулд шаардлагатай тавилга хэрэгсэл, хатуу зөөлөн эдлэл, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байгаа тул тус асуудлыг Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлэв.

В.2. Хэрэгжүүлсэн 3 төсөл, арга хэмжээнд чанарын доголдол үүссэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжиж ашиглалтад оруулах комисс хүлээн авсан ч ашиглалтын явцад болон ашиглаж эхлээгүй байхад чанарын доголдол үүссэн 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/ 2023 оны 12 дугаар сарын 15-нд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хүлээн авч ашиглаж эхлээгүй байхад 2024 оны 04 дүгээр сарын 08-ны байдлаар дараах чанарын доголдол үүссэн байна.



Барилгын дээврээс ус дотогш нэвчиж гоожсон



Гадна гэрэлтүүлгийн шон салж унасан




Өрөөнүүдийн гэрэлтүүлэг салсан, Усны хаялга дагаж мөсжилт үүссэнээс барилгын хана норсон

2. Архивын барилга /Увс, Улаангом сум/ 2023 оны 08 дугаар сарын 08-нд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хүлээн авч ашиглалтын явцад 2024 оны 03 дугаар сарын 28-ны байдлаар дараах чанарын доголдол үүссэн байна.



Барилгын дээврээс ус дотогш нэвчсэн



Ханын хэсгүүдэд цууралт өгсөн

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна”, 14.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна” гэж заасны дагуу дээрх чанарын доголдлыг арилгуулахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

3. Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 3 буюу "Цахим сургалтын тоног төхөөрөмж" (19 сумын ЕБС) 2023 оны 07 сарын 06-нд 1260 ширхэг таблетыг комисс хүлээн авч Увс аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудад хуваарилсан байна.

Хүснэгт 18. Ашиглагч байгууллагаас таблетын чанар ашиглалттай холбоотой албан бичгээр ирүүлсэн санал, тайлбаруудыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Олгосон			Ашиглагч байгууллагаас албан бичгээр авсан санал, тайлбар
		Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	
1	Цогцолбор 1-р сургууль	95	222,000	21,090,000	95ш таблет ирснээс 89ш таблетыг ашиглаж байгаа. 6 ш интернэт орохгүй байгаа тул ашиглахгүй байгаа.
2	Цогцолбор 2-р сургууль	95	222,000	21,090,000	Сул тал нь багтаамж муутай, сим орохгүй, интернэтийн хүчин чадлыг голдог, давуу тал нь хичээлийн платформд ашиглах боломжтой
3	Ахлах 3-р сургууль	60	222,000	13,320,000	Сургалтад ашиглахад үйлдлийн систем дэмжихгүй, үзүүлэлт муу EDUTEN8 PEARSON хэрэгжүүлэхэд шаардлага хангахгүй байна. 30ш-ыг ашиглаж байгаа
4	Ахлах 4-р сургууль	60	222,000	13,320,000	Хэвийн ашиглаж байна.
5	Ахлах 5-р сургууль	60	222,000	13,320,000	Интернэтийн орчинд ашиглахад удаан, апплейкешн татаж суулгах боломжгүй
6	Ахлах 6-р сургууль	60	222,000	13,320,000	Хэвийн ашиглаж байна.
7	Баруунтуруун сургууль	41	222,000	9,102,000	Хэвийн ашиглаж байна.
8	Бөхмөрөн сургууль	31	222,000	6,882,000	23 ш хэвийн ажиллаж байгаа, 8ш ажиллахгүй байгаа
9	Давст сургууль	31	222,000	6,882,000	Хэвийн ашиглаж байна.
10	Завхан сургууль	31	222,000	6,882,000	10ш удаан уншдаг, гацдаг тул ашиглахгүй байгаа. 21 ширхгийг хэвийн ашиглаж байгаа.
11	Зүүнговь сургууль	40	222,000	8,880,000	Хэвийн ашиглаж байна.
12	Зүүнхангай сургууль	40	222,000	8,880,000	40ш байгаа. Сүлжээгүй учир огт ашиглаагүй няравт байгаа.
13	Малчин сургууль	31	222,000	6,882,000	Хэвийн ашиглаж байна.
14	Наранбулаг сургууль	41	222,000	9,102,000	Хэрэглээний шаардлага бүрэн хангаж чадахгүй байна.
15	Өлгий сургууль	40	222,000	8,880,000	Ашиглах явцад сүлжээ ордоггүй, гацдаг, зарим нь огт асдаггүй, цэнэглэгч нь ажилладаггүй, хурд удаан
16	Өмнөговь сургууль	78	222,000	17,316,000	2023 онд 61ш, 2024.01.25 нд үлдэгдэл 17 ш нийт 78 ш таблет хүлээлгэж өгснөөс 5ш буцаагдсан.

17	Өндөрхангай сургууль	41	222,000	9,102,000	Хэвийн ашиглаж байна.
18	Сагил сургууль	31	222,000	6,882,000	Ашиглах явцад хүчин чадал муу, ашиглахад амархан эвдэрч байна.
19	Тариалан 1-р сургууль	61	222,000	13,542,000	Хэвийн ашиглаж байна.
20	Тариалан 2-р сургууль	20	222,000	4,440,000	
21	Түргэн сургууль	31	222,000	6,882,000	Хэвийн ашиглаж байна.
22	Тэс 1-р сургууль	61	222,000	13,542,000	Таблет EDUTEN8 PEARSON хэрэгжүүлэхэд шаардлага хангахгүй байна
23	Тэс 2-р сургууль	21	222,000	4,662,000	
24	Тэс 3-р сургууль	20	222,000	4,440,000	
25	Ховд сургууль	40	222,000	8,880,000	1 ширхэг нь анх ирэхдээ ажиллаагүй ирсэн. 10 ш нь интернэтийн сүлжээнд холбогдохгүй байгаа. 29ш хэвийн ашиглаж байна.
26	Хяргас сургууль	41	222,000	9,102,000	Хэвийн ажиллаж байгаа.
27	Цагаанхайрхан сургууль	30	222,000	6,660,000	Хэвийн ашиглаж байна.
28	Боловсрол, шинжлэх ухааны газар	3	222,000	666,000	Хэвийн ашиглаж байна.
29	Насан туршийн боловсрол, хүүхэд хөгжлийн төв	26	222,000	5,772,000	Хэвийн ашиглаж байна.
Нийт		1260		279,720,000	

Эх сурвалж: 2023 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Ерөнхий боловсролын сургуулиудаас ирүүлсэн санал, тайлбараас харахад зарим таблет ашиглалтын шаардлага хангахгүй байна.

Иймд гүйцэтгэгч компанитай 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан УВАОНӨГ/202301042 дугаартай гэрээний тусгай нөхцөлийн 9-д “Баталгаат хугацаа 1 жил байна” гэж заасны дагуу ашиглалтын шаардлага хангахгүй таблетуудыг хэвийн ажиллагаанд оруулах талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

Мөн Аймгийн хөгжимт драмын “Ойрад” театрын барилга /Увс, Улаангом сум/-тай аудитын явцад танилцаж ажлын зураг авалт хийхэд үндсэн барилга уруу ихээхэн хэмжээний ус орж мөстсөн байна.



Энэ нь барилгын чанарт нөлөөлж болзошгүй тул цаашид шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу боловсруулсан байна.
2. Улаангом политехник коллежийн дотуур байр, Хангилцагийн голын модон гүүрний ажлын нэмэлт гэрээ байгуулахдаа тендерийн хэмнэлт 2.3 сая төгрөгийг хасаж тооцоогүй байна.
3. Эрх шилжин хэрэгжсэн 19 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.
4. Эрх шилжээгүй 8, эрх шилжсэн 4 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь гүйцэтгээгүй байна.
5. Тайлант онд гүйцэтгэл гарч эрх шилжсэн 19, эрх шилжээгүй 8 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хяналт тавьж ажилласан байна.
6. Байнгын ашиглалтад хүлээн авсан 8 төсөл, арга хэмжээнд улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт бүрэн хангагдаагүй байна.
7. Хэрэгжүүлж дууссан 10 төсөл, арга хэмжээг Төрийн өмчийн хорооны шийдвэр ирээгүйгээс данс бүртгэлд тусгаагүй байна.
8. Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдсэн хүлэмжийг иргэн, аж ахуйн нэгжид үнэ төлбөргүй ашиглуулж байна.
9. Хэрэгжсэн 3 төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд бүрэн хүрээгүй байна.

**Холбогдох байгууллагын ирүүлсэн
саналд өгөх тайлбар**

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлд:

Аймгийн Засаг дарга 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 6/698 дугаар албан бичгээр “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно. Тайланд тусгах санал байхгүй болно”,

Орон нутгийн өмчийн газар 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 94 дүгээр албан бичгээр “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тухайн төсөлд өгөх санал байхгүй байна”,

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 141 дүгээр албан бичгээр “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнгийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж нэмэлт саналгүй байгааг уламжилж байна” гэсэн хариу ирүүлсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Улаангом политехник коллежийн дотуур байр, Хангилцагийн голын модон гүүрний гэрээг шинэчлэн байгуулж тендерийн хэмнэлтийг үлдэгдэл санхүүжилтээс суутган тооцох.
2. Гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй барилга байгууламжуудын ажлыг гүйцэтгэгчээр хийлгэж хүлээн авах.
3. Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдсэн иргэн, аж ахуйн нэгжид үнэ төлбөргүй ашиглуулж байгаа хүлэмжийг түрээсээр ашиглуулах асуудлыг судалж шийдвэрлэх.
4. Гэрээнд заасан чанарын баталгаат хугацаанд ашиглалтын шаардлага хангахгүй таблетуудыг хэвийн ажиллагаанд оруулах талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллах.

Аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт:

1. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах.
2. Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд Улаангом политехник коллежийн 300 ортой дотуур байр, Архивын барилгуудад үүссэн чанарын доголдлыг гүйцэтгэгч компаниар арилгуулах

Орон нутгийн өмчийн газарт:

1. Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгах асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

Аудитын дүгнэлтээс дараах саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлж байна.

1. Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/ зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглахын тулд шаардлагатай тавилга хэрэгсэл, хатуу зөөлөн эдлэл, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх асуудлаар Боловсрол, шинжлэх ухааны яаманд зөвлөмж өгөх асуудлыг Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлэв.

2. Гэрээний хугацаанд хэрэгжээгүй төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж хариуцлага тооцох асуудлыг Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлэв.

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР
БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/ М.БАТ-АМГАЛАН/

/ Б.АВИРМЭД /

/ Р.АЮУШ /

P. Ayush

УВА-2024/18-19/-ШТА -ГА

39